

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ТУСГАЙ ТОМИЛГООТ САЛБАРЫН ГҮЙЦЭТГЭХ ҮҮРГИЙН ОНЦЛОГ

FEATURES OF SPECIAL APPOINTMENT SECTOR DUTY IN BORDER SECURITY



Ц.ОДБАЯР

БХИС-ийн, Батлах хамгаалах удирдлагын академийн
Цэргийн стратегийн тэнхимийн ХЦОТ-ийн ахлах багш,
цэргийн ухааны магистр, докторант, дэд хурандаа

ODBAYAR TS.

Senior teacher, Master and Doctor Candidate of Military Science,
Lieutenant Colonel of Border Force Theory Department, Military Strategy
Department, Administration Academy of Defense, University of Defense

Товч утга: Энэ илтгэлд хилийн аюулгүй байдлыг хангахад тусгай томилгоот салбарыг ашиглаж байсан түүхэн сургамж, 1932-1990 он хүртэлх хугацааны хил хамгаалалтын зохион байгуулалт, хүн хүч, техник хэрэгслийн байдал, тусгай томилгоот салбар, бүлэг байгуулах хэрэгцээ шаардлага, үндэслэлийг тодорхойлоход оршино.

Abstract: This study covers historical facts of using special appointment sector for border security; structure, organization, manpower and facilities of border security agencies from 1932 to 1990; and need, requirement and reason for establishing special appointment sector.

Түлхүүр үгс: Хилийн цэрэг, хил хамгаалах байгууллага, хилийн отряд, хилийн застав, тусгай томилгоот салбар.

Key words: Border force, border security agency, border squad, border outpost, special appointment sector.

Дэлхийн улс орнууд ямар нэгэн хүчирхийллээс ангид байх, дайн түрэмгийлэл, сөргөлдөөнт байдлаас зайлсхийх, үй олноор хөнөөх зэвсгийг хорогдуулахыг эрмэлзэж байгаа ч газар нутаг, үндэстэн болон шашин хоорондын, эдийн засгийн ашиг сонирхол, байгалын баялгыг эзэмших, салан тусгаарлах үзлээс үүдэлтэй дайн, зэвсэгт мөргөлдөөн, аюулаас салж чадахгүй байна.

Хилийн аюулгүй байдлыг хангах тусгай томилгоот салбар, бүлгийн тухай түүхэнд хэрхэн бичиж үлдээснийг сөхөж үзвэл Монгол Улсын хил манаж, хязгаарыг хамгаалах цэрэг нь өнө эртнээс улс орны аюулгүй байдлыг хангах бодлогын тэргүүлэх зэрэгт тавигдаж ирсэн гайхамшигт түүхэн уламжлалтай билээ. Эрт дээр үед овоо бүр, одоогийнхоор багана бүрийг 1-3 айл хариуцан манадаг байжээ. Тэднийг “овоочин” гэж нэрлэж, үүнээс эх аваад гуравт, аравт, зуут, мянгатын тогтолцоогоор хилээ манаж хамгаалдаг. Тэдний ажиллагааны арга тактикийг гадаадын судлаачид тэмдэглэхдээ “Зуугаад морьтон бүслэн хаавал түмэн цэргийг хумьж чадна. Мянгын цэрэг бутраад тарвал зуун газрыг дүүргэнэ. Дайсны цэрэгтэй таарвал 3, 4, 5-аараа бутран явахаас биш бөөгнөрч дайсанд бүслэгдэх гоомой явдал огт гаргахгүй. Довтлон ирэхдээ тэнгэрээс бууж ирсэн мэт, одоходоо цахилгаан цацсан мэт... болдог”¹ гэсэн

¹ Владимирцов. Б.Я. Чингис хаан. УБ., 2001г

байна.

Мөн их эзэн Чингис хаан хил хязгаарын асуудлыг шийдээд Монгол Улсын хил хязгаарт аюулгүй байдлыг хангах үүрэгтэйгээр Мухулай, Боорчи нарыг томилж

"Өрсөлдөн ирэх дайсны өмнөх замыг бөглөж

Халдан ирсэн дайсны харайх замыг хааж,

Ирэх дайсны ирийг мохоож,

Буцах дайсны борвийг хянгард"² гэж айлдсан сургаал бий.

1932-1933 оноос эхлэн винтов, сэлэм, гарнат бүхий хоёр гурван хилчнээс бүрдсэн шаардлагатай үед пулеметоор, хүч нэмэгдүүлсэн тасгаар хилийн манааг бүрдүүлж байжээ. Харин 3-4 тасагтай салааны зэрэгтэй заставыг отрядын хил манах үндсэн хүчин байх тогтолцоог бий болгожээ. Хил дээр гарсан ноцтой зөрчлийг тухайн чиглэлд богино хугацаанд хамтарсан хүчээр шийдвэрлэх боломж бүрдүүлэхийн тулд 3-4 заставын дунд аль нэгэн заставт мөн тодорхой хэмжээний тасгаас доошгүй хүч нэмэн байгуулж (Тусгай томилгоот салбар, бүлэг. Ц.О) тэнд удирдлагын офицерыг комендант хэлбэрээр бий болгон хожим сумангийн зэрэглэлтэй хүч болгон ашиглав. Харин отрядын төвд гол төлөв винтов пулемет бүхий 2-3 салааны бэлтгэл хүч бий болгон, шаардлагатай үед отрядын хэсэгт бэлтгэл хүчээр туслах (Тусгай томилгоот салбар, бүлэг. Ц.О) аргыг сонгожээ. Эндээс улбаалан отряд нь 2-3 комендант буюу суман, харин комендант (суман нь) 3-4 засталаас, застав нь 3-4 тасгийн бүтэцтэй зохион байгуулалтанд оржээ. Энэ тогтолцоо хилийн цэргийг татан буулгасан 1953 он хүртэл үйлчилжээ.

Дэлхийн II дайны дараа байнгын цэргийг цөөрүүлэн татан буулгаж энхийн хөдөлмөрт хүчийг үр дүнтэй ашиглах үүднээс төрөөс шийдвэр гаргасан байна. Энэ нь зөв алхам боловч "10570 хүний бие бүрэлдэхүүн бүхий хилийн цэргийн байгууллагыг бүхлээр нь татан буулгаж 213 хүн"³ үлдээсэн нь бодит байдалд нийцсэнгүй. Өөрөөр хэлбэл, 1 км хилийн хэсэгт 1,3 хүн ноогдох нягтралтай байсныг 37 км хэсгийг нэг хилчин манах зүй бус боломжгүй тогтолцоотой болгож улсын хил тогтоогдож амжаагүй тэр үед хил хязгаар эзэнгүйдэн нутаг дэвсгэрээсээ алдах аюултай тулгарчээ.

Хилийн цэргийг дахин байгуулснаас хойш Хил хамгаалах байгууллага, хилийн отрядуудын бүтэц, зохион байгуулалт нь 1977 оноос хойш боловсронгуй болсоор 1990 оны эхэн хүртэл нэг отряд дунджаар 430 орчим километр хилийн хэсгийг хариуцан, бие бүрэлдэхүүний тоо 500-1000 хүрч, хороо-бригадын зэрэгтэй болсон байна. Хилийн отряд нь 6-12 хилийн заставтай, төвдөө 100-250 хүртэл бие бүрэлдэхүүнтэй, маневрын (рот) бүлэгтэй (Тусгай томилгоот салбар, бүлэг. Ц.О), алслагдсан гол чиглэлийн отрядуудад зенитийн ба миномётын батарейтай байжээ. Мөн отряд бүр холбоо, инженер, хими, техник барилга, үйлчилгээний тусгай салаатай, орон тооны буудлагын нэг бүрийн ба салбарын зэвсгээр хангагдаж, отрядод 10-15 "БТР-60ПБ", хуягт тээвэрлэгч, тагнуулын "БРДМ" хоёр, 15-20 хөнгөн тэрэг, 25-40 ачааны ба тусгай зориулалтын техниктэй байсан ба хилийн отряд нь 400 км² талбайд хил зөрчигчийг эрж баривчлах, 8 хүртэлх хүнтэй тагнуулын хорлон сүйтгэх 7-10 бүлгийг устгах, зэвсэгт халдлага тохиолдсон үед дайсны явган цэргийн ротыг явдлаас давшин устгаж, батальон хүртэлх хүчийг няцаах, отрядын даргад

² Монголын нууц товчоо 149 дүгээр зүйл

³ Д.Гомбосүрэн. Монгол цэргийн товчоо (1911-1991) дэд дэвтэр. БХЯ. ЭШХ .УБ, 1996 он

зэвсэгт хүчний анги нэгтгэлүүдээс хүч хавсаргах хэрэгсэл өгөгдсөн тохиолдолд эсрэг талын явган цэргийн батальон хүртэлх хүчийг устгах, хоёр батальоны хүчийг няцаах, саатуулах боломжтой байжээ.

Хилийн заставууд нь мотоцикл, УАЗ-469, ГАЗ-66 маркийн машинтай болж гранатамёт, тасаг ротын пулемёт, зарим чиглэлд прожектор, радиолокацын станц, С-100 маркын дохиоллын хэрэгсэл, улсын хилийн зарим хэсэгт инженер техникийн хэрэгслээр төхөөрөмжлөгдөж хүч нэмэгдүүлсэн 4-5 тасгийн бүтэцтэй болсон учраас биеэ даасан сумангийн зэрэгтэй болж отрядад шууд захирагдах тогтолцоо бий болов.

Хилийн бүх отрядуудын төвд 3-4 салаа бүхий тусгай зориулалтын болон БТР-ПВ, БРДМ хуягтад суурилсан суман, зарим отряд тухайлбал хилийн гурван отрядод батальоны зэрэглэлтэй манёврийн групп бүхий бэлтгэл хүчтэй болж алслагдсан ба чухал чиглэлд тооцогддог хилийн 0198, 0129, 0130 дугаар ангиуд агаарын довтолгооноос өөрийгөө хамгаалах зенитийн салбар мөн 2-4 км зайд буй хүчийг галаар дарах, устгах, миномётын салбартай болжээ. Үүний зэрэгцээ аль ч чиглэлийн хилийн анги, заставуудад шаардлагатай үед 3-15 хоногоор нисдэг тэргээр хүч нэмэгдүүлэн ашиглах мөн Улаанбаатараас шаардлагатай үед 1-3 цагийн хугацаанд багтаан хилийн ангиуд нисэх онгоцоор бэлтгэл хүчийг төвөөс авах бололцоотой байжээ.

Энэ бүхэн нь Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэн 1990 оноос хойш хил хамгаалах байгууллагын бүтэц, орон тоонд өөрчлөлт хийгдэж, техникийн ашиглалт, хангалт багассан, техник хэрэгслэлийн ашиглалтын норм хугацаа дуусч нөхөн хангалтгүй болсон, 2003 оноос хойш Хил хамгаалах байгууллага бүсчилсэн хил хамгаалалтад шилжин ажиллах эрх зүйн орчныг бий болгож байгаа нөхцөл байдалд бүсүүдийн төвүүдийн дэргэд тусгайлан бэлтгэгдсэн чадварлаг хүн хүч, техник хэрэгсэл бүхий тусгай томилгоот салбар (бүлэг)-ыг байгуулж, тухайн бүс нутагт үүссэн оператив-тактикийн хэмжээний хилийн зөрчлийг таслан зогсоох үүрэг гүйцэтгүүлэх нь энэ асуудлаар цаашид судалгаа хийх зайлшгүй шаардлага урган гарч байна.

Өнөө үед хилчид, хил хамгаалах байгууллагын хувьд улсын хилийн баталгаажилт хамгаалалтыг шийдвэрлэх амаргүй зорилт тулгарч байна. Энэ нь сансар, мэдээлэл даяаршлын эрин зууны онцлогт тохирсон, НҮБ-ын дүрэм бусад олон улсын эрх зүй, хүн төрөлхтний гурав дахь мянганы зорилт, Монгол Улсын биеэ даасан хөгжлийн эрх ашигт нийцүүлэн улсынхаа хилийн аюулгүй байдлыг хангах зорилгоос урган гарч байна.

XXI зууны хилийн асуудлыг XX зууны зэвсэглэл техник хэрэгсэлд дулдуйдсан хүч хэрэгслээр манах, хамгаалах бололцоо хоног хоногоор хумигдсаар оронд нь сансар-агаар-газрын хосолсон мэдээлэл, роботчлол, автоматчлал, илрүүлэлт, саатуулалт, устгалт нь мадаггүй магадлал бүхий техник хэрэгсэл ашиглаж, мэргэшсэн хилчид хил манаж, хамгаалах зарчмын шинэ шатанд шилжиж байна.

Мөн хил дамнасан олон улсын гэмт хэрэг, дэлхийн эдийн засгийн хямралаас үүдэн гарч буй сөрөг үзэгдлүүд нь улсын хил, түүний орчинд хурцаар илэрч Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд бодитоор нөлөөлөх болов. Улсын хилийг хууль бусаар зөрчих, зэвсгийн болон хүний наймаа, алан хядах ажиллагаа, мансууруулах бодис, хар тамхины худалдаа, байгалийн баялгыг хууль бусаар хил давуулах (алт,

байгалийн үнэт чулуу) зэрэг уламжлалт бус аюулын асуудал хүрээгээ тэлж, хилийн бүс зурваст ашигт малтмал олборлох ажиллагаа, түүнийг дагасан сөрөг нөлөөлөл нэмэгдэж байгаа, Монгол Улсын хил хамгаалалт нь байнга чанаржиж ахуйн чанартай зөрчлөөс аваад Үндэсний аюулгүй байдалд ч нөлөөлж болох эдийн засаг, хүн ам, байгаль экологийн эсрэг чиглэсэн томоохон зөрчлүүдийг таслан зогсоох хүртэл алба-байлдааны үйл ажиллагаагаа явуулах чадвартай болох, бүсчилсэн хил хамгаалалтын үзэл баримтлалын дагуу бүс нутгийн хэмжээнд бий болсон хилийн зөрчил, террорист халдлага, бусад үүсэн бий болсон нөхцөл байдлыг таслан зогсоох нь тулгамдсан асуудал болж, түүнтэй тэмцэх хил хамгаалах байгууллагын ажиллагааг шинэ нөхцөл байдалд шинэлэг арга, хэлбэрүүдээр явуулахыг шаардаж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл санаанд нийцүүлэн Улсын Их хурлаас батлан гаргасан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын үндэс”, “Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого” баримт бичгүүд, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, “Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хууль, Хилийн тухай хууль зэрэг эрх зүйн актаар хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны ерөнхий чиглэлийг тогтоожээ.

Мөн хил хамгаалалтын дүрэм, хилийн албаны бэлэн байдлын оперативын удирдамжаар хилийн отрядын хариуцсан хэсэгт үүссэн нөхцөл байдлын үед ажиллах бүлэг, түүний гүйцэтгэх үүргийг заасан боловч бүс нутгийн хэмжээнд гарсан хилийн зөрчил, түүнийг таслан зогсоох ажиллагааны талаар тодорхой заалт, журам байхгүй зөвхөн ХХЕГ-аас оператив бүлэг, хилийн 0303 дугаар тусгай салбараас томилогдсон бүлэг ажиллахаар тусгагдсан байна.

Улс орон зах зээлийн харилцаанд шилжсэн үед хилийн ... дугаар отрядуудын хариуцсан хэсгээр хууль бусаар ноолуур, машин гаргах хэлбэрийн хилийн зөрчил 1993-1997 оны хооронд гарсан бөгөөд үүнд хилчид ч оролцож байсан байна. Мөн хилийн ... дугаар отрядуудын хариуцсан хэсгээр спирт, самар хил давуулан их хэмжээний ашиг олох, ... отрядын хариуцсан хэсгээр 1996 оноос эхлэн мансууруулах төрлийн өвс ургамал түүх хэлбэрийн шинэ зөрчил гарах болжээ.

Энэ нь улс орны нийгэм эдийн засаг уналтад орж ард иргэдийн дунд ажилгүйдэл, ядуурал газар авсантай холбоотой. Мөн Увс, Хөвсгөлийн чиглэлээр хулгайн ан агнах, мал хулгайлах явдал жил ирэх тусам өсч, Дорнодын хариуцсан хэсэг, Увс, Тувагийн хил орчим хил зөрчигчид зэвсэг хэрэглэж хүний амь нас удаа дараа хохирч, ард иргэдийн дунд айдас түгшүүр буй болж, эд хөрөнгө, мал хуйгаа туун хязгаар нутгаас нүүн дүрвэх явдал гарч байжээ.

Дээрх үйл явдалд Хилийн цэрэг удаа дараагийн дорвитой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн байна. Хилийн цагийн байдлыг үнэлэн Дорнодын хэсэгт 1996 онд “Хэрлэн”, 1997 онд “Зурвас”, Увсын хэсэгт 1998 онд “Намар”, 1999 онд “Хавар”, 2001 онд Цөлийн салхи операциудыг явуулж, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангажээ.

Манай хойд хөрш Оросын холбооны улсын Хилийн тойргуудын жишгийг

сонирхож үзвэл: журам мэт 5-16 отряд, 1-6 тусгай бригад (хилийн харуулын хөлөг бүхий) 1-9 хилийн шалган нэвтрүүлэх боомтууд, 1-3 нисэх тусгай эскадриль, холбооны тусгай батальон, инженерийн барилга байгууламжийн тусгай батальон, 1-3 тойргийн агуулах, эмнэлэг, 1-3 сургуулийн отрядууд байх бөгөөд үндсэндээ 100 гаруй салбар багтаасан 15-40 нэгтгэл ангиудаас бүрддэг ажээ.⁴ ОХУ нь 60000 км урт хилийг хамгаалах нэгдмэл тогтолцоондоо нэг тойрогт дунджаар 1500-2500 орчим километр урт хэсгийг хариуцуулдаг байна.

Манай орны нөхцөлд түр буюу байнгын хилийн цэргийн оператив нэгж бүлгийг байгуулах тохиолдолд дээрх ерөнхий бүтэц, орон тоог баримтлахад хүндрэлтэй. Иймд өмнө байсан Хилийн төлөөлөгчийн газруудад түшиглэн хилийн стратеги, оператив-стратегийн зорилтыг оперативын масштабт хэрэгжүүлэх нөхцөлд хил хамгаалалтын оперативын нэгж болох Хилийн цэргийн оператив бүлэг буюу нэгж нь бүрэлдэхүүндээ 2-3 хилийн отряд, 1-2 хилийн шалган нэвтрүүлэх отряд, боомттой, нисэх салаа (нисдэг тэрэгний 1-2 экипаж), холбооны тусгай рот, инженерийн тусгай рот, эмнэлэг (лазарет), сургуулийн болон аж ахуйн үйлчилгээний рот, зэвсэг техникийн болон засварын нэгж бүхий 2000 хүртэл км хэсгийг хариуцсан байдалтай байж болох юм⁵.

Хилийн цэргийн оперативын бүлгийн хүч хэрэгслийг цагийн байдлын ямар ч үед шуурхай шилжүүлэх, маневрлах, дэлгэн байрлуулах нөхцөлийг хангасан байх бөгөөд нөгөө талаар улсын хил хамгаалалтын байгууламж нь хамгаалалтын найдвартай тасралтгүй байдлыг хангах, хүч хэрэгслийг цогцолбороор ашиглах, уян хатан байх, гэнэтийн, нууц далд, идэвхтэй байх ажиллагааг хангах, харилцан ажиллагааны тасралтгүй байх нөхцөл бүрдүүлэх, гол чиглэлд хүч хэрэгслийг нэмэгдүүлэх, төвлөрүүлэх гэсэн зарчмуудад нийцүүлсэн байх шаардлагатай юм.

Дүгнэлт

Хилийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий тусгай томилгоот салбар, бүлгийн хүч хэрэгслээр хил орчмын нутаг дэвсгэрт үүсэх онцгой нөхцөл байдалд уг асуудлыг зохицуулах, зэвсэгт хүчин, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг бүхий байгууллагуудын харилцан ажиллагаа бүхий нэгдсэн тогтолцоо, хилийн отрядын гүйцэтгэх үүрэг болон уг ажиллагааны сургалт бэлтгэлийн талаар тусгайлан хийсэн судалгаа шинжилгээний бүтээл, ном, сурах бичиг, гарын авлага хараахан гараагүй байна.

Хилийн аюулгүй байдлыг хангах тусгай томилгоот салбарыг бүс нутгийн хэмжээнд буюу хилийн 3-4 отрядын дунд байгуулж, оператив-тактикийн түвшинд бэлтгэж явуулах асуудал нь Монгол Улсын үндэсний язгуур эрх ашгийг улсын хил орчмын хязгаар нутагт хамгаалах харилцан хамааралтай хөгжлийн шинж агуулгатай, нийгмийн өвөрмөц үзэгдэл бөгөөд энэ нь Хил хамгаалах ерөнхий газар, хилийн цэргийн алба байлдааны ажиллагааны эрэлтийг хангасан бодит хэрэгцээ шаардлага болж байна.

⁴П.К.Алтухов. Основы теории управления войсками. м., 1984 г

⁵ Н.Наранжамц. Тал хээрийн нөхцөлд хилийн операци зохион байгуулж явуулах нь. Докторын зэрэг горилсон диссертаци.. УБ. 2006 он